



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 4 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

## Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Усан спорт сургалтын төвийн дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тус төвийн дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Болдсайханд үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны  
 808 дугаар захирамжийн хавсралт

**УСАН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВИЙН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Усан спорт сургалтын төв нь нийслэлийн хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, усан спортын төрлөөр хичээллэгсдийг сургах, ур чадварыг дээшлүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, усан спортын мэргэжлийн сургалт-арга зүй-үйлчилгээний байгууллага мөн.
2. Усан спорт сургалтын төв /цаашид УССТ гэх/ төрийн үйлчилгээний байгууллага болохын хувьд үйл ажиллагаа нь Монгол Улсын Засгийн газрын бодлого, нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн холбогдох зорилтуудыг ханган биелүүлэхэд чиглэгдэнэ.
3. УССТ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, нийслэлийн Засаг даргын захирамж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.
4. УССТ нь өөрийн билэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.
5. УССТ нь Биеийн тамир спортын үндэсний төв, нийслэлийн Биеийн тамир спортын болон Эрүүл мэндийн газар, холбогдох бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

**Хоёр. Удирдлага, бүтэц зохион байгуулалт**

1. УССТ нь нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харъяанд ажиллах бөгөөд төвийн даргыг нийслэлийн Засаг даргын захирамжаар томилно.
2. УССТ-ийн бүтэц, орон тоо, төсвийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн бодлогын хэлтсээс хянаж, Засаг дарга баталгаажуулна.
3. УССТ-ийн өмч хөрөнгийг эзэмших, ашиглахтай холбоотой асуудлыг нийслэлийн Өмчийн харилцааны газартай байгуулсан гэрээгээр зохицуулна.
4. УССТ-ийн дарга нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана. Үүнд:
  - а/ батлагдсан бүтэц, цалингийн сан, төсөвтөө багтаан УССТ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах.
  - б/ УССТ-ийн гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар зохих хууль тогтоомж, журмын дагуу ажиллах.

в/ төсвийн хөрөнгө, биеийн тамир спортын арга хэмжээний төвлөрсөн төсөв, өөрийн үйл ажиллагаанаас олох орлого, хандив, зээл тусламж зэргийг захиран зарцуулах.

г/ Монгол Улсын хууль тогтоомж, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр олгосон бусад бүрэн эрх.

5. УССТ-ийн дарга нь өөрийн бүрэн эрхийн асуудлаар тушаал гарган биелэлтийг хангуулна.

6. УССТ нь банкинд өөрийн харилцах төгрөгийн болон валютын данстай байна.

7. УССТ нь гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, компани, иргэдийн хандив, ивээн тэтгэгчдийн тусламжийг төвлөрүүлэн Усан спортыг дэмжих санг байгуулж болох бөгөөд усан спортыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэхэд сангийн үйл ажиллагаа чиглэгдэнэ.

8. УССТ-ийн даргын дэргэд захиргааны зөвлөлийг байгуулж ажиллах бөгөөд түүний ажиллах журмыг төвийн дарга батлана.

9. УССТ-ийн даргын дэргэд орон тооны бус усан спортын мэргэжлийн зөвлөл ажиллуулж болно. Мэргэжлийн зөвлөл нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байвал зохино. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг төвийн дарга батлана.

**Гурав. Усан спорт сургалтын төвийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг**

1. Усан спортыг хөгжүүлэх, байгууллагын өмнө тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх талаар асуудал боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж шийдвэрлүүлэх.

2. Хүн амыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, усан спортыг хөгжүүлэх талаар гарсан төр засаг, удирдах дээд байгууллагын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3. Эрүүл мэндийн байгууллагуудтай биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлын талаар хамтран ажиллах, хүн амын дунд усан спортыг сурталчлах, дэлгэрүүлэх арга хэмжээ авах.

4. Хөрөнгө оруулалт, төсвийг оновчтой, хэмнэлттэй зарцуулж, бассейны барилга байгууламж, тоног төхөөрөмж, материал хэрэглэлийн хангамжийг сайжруулах.

5. Усан спортын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

6. Усан спортын мэдээлэл сурталчилгааг хэвлэл мэдээллийн болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, арга зүйн ном, гарын авлага, зөвлөмжүүдийг бэлтгэж хэвлэх.

7. Төрийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, усан спортыг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг

сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулсан хүмүүсийг төр засгийн шагналаар шагнуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

8. Нийслэлийн хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, усан спортын дасгал хөдөлгөөнөөр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

9. УССТ-ийн барилга байгууламжийг үр дүнтэй ашиглах, засвар, тохижилт, үйлчилгээг сайжруулах, усны ариутгал, эрүүл ахуйн болон аюулгүйн горим, технологийн шаардлагыг ханган ажиглах.

10. Усан спортыг хөгжүүлэх, үндэсний баг тамирчдыг бэлтгэх, боловсон хүчнийг чадваржуулах, мэргэжлийг нь дээшлүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах зэрэг асуудлаар гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг болно.

### **Дөрөв. Санхүүжилтийн эх үүсвэр**

1. УССТ-ийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

а/ нийслэлийн төсөв

б/ өөрийн үйл ажиллагаанаас олох орлого

в/ иргэд, аж ахуйн нэгжийн хандив, тусламж

г/ банкны зээл

д/ бусад